



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Заавар, аргачлал батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 15 дугаар зүйлийн 15.1.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:


1. "Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2. Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах үйл явцыг цахим хэлбэрт шилжүүлэх, програмчлах ажлыг Стратегийн удирдлагын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /Д.Энхболд/-д хариуцуулсугай.


3. Төрийн аудитын байгууллагын захиалгаар хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг энэхүү заавар, аргачлалыг дагуу үнэлж, тайлагнах ажлыг зохион байгуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторуудад үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын Төрийн аудитын төрөлжсөн байгууллагуудыг хариуцсан орлогч /С.Оюунбилэг/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР




ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ
ЗААВАР, АРГАЧЛАЛ

2018 он

Агуулга

Нэг. Ерөнхий зүйл.....	2
Заавар боловсруулах үндэслэл, шаардлага.....	2
Зааврын зорилго, үнэлгээний явцад баримтлах зарчим.....	2
Хамрах хүрээ	2
Хоёр. Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт, аргачлал	3
Ерөнхий үнэлгээ гаргах үндсэн үзүүлэлт	3
Ерөнхий үнэлгээ гаргах аргачлал	4
Ерөнхий үнэлгээнд харгалзах бусад үзүүлэлт	7
Гурав. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлын зохион байгуулалт, оролцогч талуудын үүрэг, оролцоо.....	7
Дөрөв. Үнэлгээг баталгаажуулах, шийдвэр гаргах	8

Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2018 оны 04 дүгээр сарын 02 - ны өдрийн
А/6-4 дугаар тушаалын хавсралт



**ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ТАЙЛАГНАХ
ЗААВАР, АРГАЧЛАЛ**

Нэг. Ерөнхий зүйл

Заавар боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмыг тус тус үндэслэн хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын гэрээт ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал боловсруулав.

1.2 Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, цаашид аудитыг оновчтой, бодитой төлөвлөх үндэслэл болох мэдээлэл цуглуулах шаардлага Төрийн аудитын байгууллагын өмнө тулгардаг.

Зааврын зорилго, үнэлгээний явцад баримтлах зарчим

1.3 Төрийн аудитын байгууллагын захиалгаар санхүүгийн тайлангийн аудит хийсэн хараат бус аудитын хуулийн этгээдийн гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх бодлого, аргачлалыг тодорхойлоход энэхүү зааврын зорилго оршино.

1.4 Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнахад ил тод, шударга, бодитой байх үндсэн зарчмаас гадна үнэлгээний дүн, дүгнэлт төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт, холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх зарчим баримтална.

Хамрах хүрээ

1.5 Хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн аудитын ажлын гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах, гүйцэтгэлийг тайлагнах, баталгаажуулах үйл явц энхүү зааварт хамаарна.

1.6 Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас сонгон шалгаруулсан хараат бус аудитын хуулийн этгээдийн тухайн тайлант хугацаанд гүйцэтгэсэн санхүүгийн аудитын явц, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэлд үндэслэн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ.

Хоёр. Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үзүүлэлт, аргачлал

Ерөнхий үнэлгээ гаргах үндсэн үзүүлэлт

2.1 Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ дараах үндсэн үзүүлэлтийг үндэслэл болгоно. Үүнд:

2.1.1 Аудитын ажлын даалгавар болон аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт дурдсан санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын гүйцэтгэл, чанарт өгсөн үнэлгээ.

2.1.1.1 ажлын баримт материал бүрдүүлэлтийн хувь;

2.1.1.2 үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал;

2.1.1.3 үе шатны ажлын чанарын хяналтын үнэлгээ.

2.1.2 Хараат бус аудитын хуулийн этгээдийн аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчлийн нийт дүнд эзлэх хувь оролцоо.

2.1.2.1 аудитын явцад хийсэн залруулгын дүнд эзлэх хувь;

2.1.2.2 хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөжийн дүнд эзлэх хувь;

2.1.2.3 төлбөрийн актын дүнд эзлэх хувь¹;

2.1.2.4 албан шаардлагын дүнд эзлэх хувь²;

2.1.2.5 зөвлөмжийн дүнд эзлэх хувь;

2.1.2.6 сахилгын хариуцлага тооцуулах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн дүнд эзлэх хувь³

2.1.3 Хараат бус аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээг дараах үзүүлэлтүүдийн дундаж хувиар тодорхойлогдоно. Үүнд:

2.1.3.1 төлбөрийн актын барагдуулалтын хувь;

2.1.3.2 албан шаардлагын барагдуулалтын хувь;

2.1.3.3 зөвлөмжийн биелэлтийн хувь.

¹ ТАХ-ийн 15.1.12

² ТАХ-ийн 15.1.12

³ ТАХ-ийн 15.1.13

Ерөнхий үнэлгээ гаргах аргачлал

2.2 Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээний үндсэн үзүүлэлтийг энэ зааврын 2.1, 2.2-т заасан үзүүлэлтээр дараах аргачлалын дагуу гаргана. Үүнд:

2.2.1 Ерөнхий үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцож гаргана.

$$EY = \frac{ЧХЕУ + ХО + ТЗБҮ}{3}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

(EY) – Ерөнхий үнэлгээ

(ЧХЕУ) – Чанарын хяналтын ерөнхий үнэлгээ

(ХО) – Хувь оролцоо

(ТЗБҮ) – Төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээ

Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг нэгтгэж, баталгаажуулах маягтыг Хавсралт №1-д үзүүлэв.

2.2.1.1 Энэ зааврын 2.2.1-д дурдсан чанарын хяналтын үнэлгээг (ЧХЕУ) дараах аргачлалын дагуу тооцож гаргана.

$$\text{ЧХЕУ} = \frac{АББХ + ГХ + ЧХҮ}{3}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

АББХ – Ажлын баримт материал бүрдүүлэлтийн хувь

ГХ – Гүйцэтгэлийн хугацаа буюу үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал

ЧХҮ – Үе шатны ажлын чанарын хяналтын үнэлгээ

Чанарын хяналтын ерөнхий үнэлгээг тооцож гаргахдаа Санхүүгийн тайлангийн удирдлагын системд оруулсан санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын баримт, цаг хугацаа, аудитын явцад өгсөн чанарын хяналтын үнэлгээ зэрэг мэдээлэлд үндэслэн холбогдох маягаар тооцоолж гаргана. Эдгээр тооцоолох, нэгтгэх үйлдлийг програм хангамжийн тусламжтай автоматаар гүйцэтгэнэ. Үүнд:

а) **Ажлын баримт бүрдүүлэлтийн хувийг тодорхойлохдоо Хавсралт № 2-т заасан мэдээлэлд үндэслэнэ.**

- b) **Гүйцэтгэлийн хугацаа буюу үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан эсэхийг тодорхойлоход Хавсралт № 3 маягтыг ашиглана.**
- c) **Үе шатны ажлын чанарын хяналтын үнэлгээг Хавсралт № 4 маягтаар нэгтгэнэ.**

2.2.1.2 Хувь оролцоо (ХО) буюу хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн ажлын нийт үр дүнд оруулсан хувь нэмрийг дараах аргачлалын дагуу тооцож гаргана.

$$ХО = \frac{\frac{ЗАЛ}{ЗАЛ^1} + \frac{ҮӨ}{ҮӨ^1} + \frac{ТА}{ТА^1} + \frac{АШ}{АШ^1} + \frac{ЗӨ}{ЗӨ^1} + \frac{СХ}{СХ^1}}{6}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

(ЗАЛ) –Тухайн нэгжийн тайлант хугацаанд хийсэн нийт залруулгын дүн

(ЗАЛ¹) – Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн залруулгын нийлбэр дүн

(ҮӨ) – Тухайн нэгжийн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрүүлж, бүртгэсэн үр өгөөжийн дүн

(ҮӨ¹) – Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн хүлээн зөвшөөрүүлж, бүртгэсэн үр өгөөжийн нийлбэр дүн

ТА - Тухайн нэгжийн тайлант хугацаанд тогтоосон төлбөрийн актын дүн

(ТА¹) – Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн тогтоосон төлбөрийн актын нийлбэр дүн

(АШ) – Тухайн нэгжийн тайлант хугацаанд өгсөн албан шаардлагын дүн

(АШ¹) - Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн өгсөн албан шаардлагын нийлбэр дүн

(ЗӨ) – Тухайн нэгжийн тайлант хугацаанд өгсөн зөвлөмжийн тоо

(ЗӨ¹) - Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн өгсөн зөвлөмжийн тоо

(СХ) – Тухайн нэгжийн тайлант хугацаанд гаргасан сахилгын шийтгэл ногдуулах саналын тоо

(СХ¹) - Тайлант хугацаанд бүх хараат бус аудитын хуулийн этгээдийн гаргасан сахилгын шийтгэл ногдуулах саналын нийт тоо

Жич: Аудитын явцад илрүүлсэн зүйлсийн талаарх мэдээллийг аудит тус бүрээр авах бөгөөд энэ нь тухайн тайлант хугацааны гэрээгээр гүйцэтгүүлсэн санхүүгийн аудитын нийт илрүүлэлтэд эзлэх хувь оролцоогоор тодорхойлогдоно.

Хувь оролцооны коэффициентийг ерөнхий үнэлгээнд нэгтгэхдээ тухайн байгуулагын батлагдсан төсөвт ногдох хувиар тооцно.

Хувь оролцоог тодорхойлохдоо Хавсралт №5-д заасан үзүүлэлтэд үндэслэнэ.

2.2.1.3 Төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээ (ТЗБҮ) буюу хараат бус аудитын хуулийн этгээдийн илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээг дараах аргачлалын дагуу тооцож гаргана.

$$\text{ТЗБҮ} = \frac{\text{ТАБ} + \text{АШБ} + \text{ЗӨБ}}{3}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

(ТАБ) – Төлбөрийн актын биелэлтийн хувь

(АШБ) – Албан шаардлагын биелэлтийн хувь

(ЗӨБ) – Зөвлөмжийн биелэлтийн хувь

Дээрх 3 үзүүлэлтийг дараах аргачлалын дагуу тооцож гаргана.

$$\text{ТАБ} = \frac{\text{ҮТБ} + \text{ТХБ}}{2} \quad \text{АШБ} = \frac{\text{ҮАШБ} + \text{ТХАШБ}}{2} \quad \text{ЗӨБ} = \frac{\text{ҮЗБ} + \text{ТХЗБ}}{2}$$

Товчилсон үзүүлэлтийн тайлбар:

(ҮТБ) – Өмнөх тайлант хугацааны барагдуулаагүй үлдэгдэл төлбөрийн актаас тайлант хугацаанд барагдуулсан хувь

(ТХБ) – Тайлант хугацаанд тогтоосон төлбөрийн актын барагдуулалтын хувь

(ҮАШБ) – Өмнөх тайлант хугацааны биелүүлээгнүй албан шаардлагаас тайлант хугацаанд барагдуулсан хувь

(ТХАШБ) – Тайлант хугацаанд өгсөн албан шаардлагын барагдуулалтын хувь

(ҮЗБ) – Өмнөх тайлант хугацааны биелүүлээгүй зөвлөмжөөс тайлант хугацаанд барагдуулсан хувь

(ТХЗБ) – Тайлант хугацаанд өгсөн зөвлөмжийн биелэлтийн хувь

Жич: Үлдэгдэл төлбөр, зөрчил, зөвлөмж гэдэгт өмнөх онуудад илрүүлээд барагдуулаагүй байсан төлбөр, зөрчил, зөвлөмжийн барагдуулаагүй үлдэгдлийг өссөн дүнгээр тооцно. Хэрэв тийм үлдэгдэл байхгүй бол үлдэгдэл төлбөр, зөрчил, зөвлөмжийг "1" гэж тооцно.

Ерөнхий үнэлгээнд харгалзах бусад үзүүлэлт

2.3 Төрийн аудитын байгууллагаас тухайн тайлант хугацаанд дэвшүүлсэн бодлого, зорилттой уялдсан бусад харгалзах үзүүлэлтийг үндэслэн энэ зааврын 2.1-д заасан ерөнхий үнэлгээг өсгөх буюу бууруулах арга хэмжээ авч болно.

2.3.1 Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг дараах тохиолдолд нэмэгдүүлнэ. Үүнд:

2.3.1.1 төсвийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах чиглэлээр тусгайлан боловсруулсан санал нь төсвийн төсөлд тусгагдсан бол ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг 10 хувиар;

2.3.1.2 санхүүгийн тайлангийн аудитын бодлого, арга зүйг боловсронгуй болгох оновчтой санал, санаачлага гаргаж, төрийн аудитын байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн бол ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг 10 хувиар;

2.3.2 Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг дараах тохиолдолд бууруулна. Үүнд:

2.3.2.1 хараат бус аудитын хуулийн этгээд, түүний ажилтан гэрээний үүргээ зөрчиж, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан нь нотлогдвол тухайн байгууллагын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг 30 хувиар;

2.3.2.2 Хараат бус аудитын хуулийн этгээд санхүүгийн тайлангийн аудит хийхээр гэрээ байгуулсан боловч хүндэтгэх шалтгаангүйгээр аудит хийгээгүй, санал дүгнэлт гаргаагүй бол ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг хийгээгүй аудитын тоог хийх ёстой санхүүгийн аудитын дүнд эзлэх хувийн жингээр;

2.4 Тухайн тайлант хугацаанд хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн аудитад чанарын баталгаажуулалтын хяналт хийсэн бол Чанарын баталгаажуулалтын албаны саналыг үндэслэн ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээнд өөрчлөлт оруулж болно.

Гурав. Ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлын зохион байгуулалт, оролцогч талуудын үүрэг, оролцоо

3.1 Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх бодлого, арга зүйг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг нэгтгэж, тайлагнах, дүн шинжилгээ хийх ажлыг Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар удирдан зохион байгуулна.

3.2 Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрууд өөрсдийн сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг аудитын менежер аудитын санал дүгнэлт гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор энэ зааврын дагуу үнэлж, тэргүүлэх аудитор хянаж, баталгаажуулна.

3.3 Энэ зааврын 3.2-т заасан санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээний дүнг тухайн гүйцэтгэгч байгууллагын удирдагч танилцуулж, хүлээн зөвшөөрсөн эсэхийг Хавсралт № 1-д заасан маягаар баталгаажуулна.

3.4 Төрийн аудитын байгууллагын захиалгаар Санхүүгийн аудит хийхээр гэрээ байгуулсан хараат бус аудитын хуулийн этгээд гэрээний үүргийн биелэлт, хийсэн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл явцад дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.4.1 Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлтэй холбоотой дараах баримт материалыг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж, Төрийн аудитын байгууллагад ирүүлэх:

3.4.1.1 Энэ журмын Хавсралт № 2-6-д заасан маягаар холбогдох мэдээллийг гаргаж ирүүлэх;

3.4.1.2 Төрийн аудитын байгууллагаас шаардсан гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой бусад тайлбар, лавлагааг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлэх.

3.5 Хараат бус аудитын хуулийн этгээд гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой асуудлаар Төрийн аудитын байгууллагаас тайлбар, тодруулга авч болно.

3.6 Энэ зааврын 3.2-т заасан үнэлгээний дүнд Үндэсний аудитын газрын Дотоод аудитын алба нэгдсэн байдлаар хараат бус хяналт – шинжилгээ хийнэ.

3.7 Дотоод аудитын алба хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлд хийсэн хяналт – шинжилгээний дүнг төрийн аудитын байгууллагын хэмжээнд нэгтгэн Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

Дөрөв. Үнэлгээг баталгаажуулах, шийдвэр гаргах

4.1 Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар хараат бус аудитын хуулийн этгээдийн тухайн тайлант хугацаанд гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээг⁴ гүйцэтгэгч тус бүрээр нэгтгэж, цаашид хэрхэн хамран ажиллах санал, танилцуулга бэлтгэнэ.

4.2 Стратегийн удирдлагын газар энэ зааврын 2.3.1.1, 2.3.1.2-т заасан ерөнхий үнэлгээг өсгөх саналыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас холбогдох нотлох баримт, тайлбар, танилцуулгын хамт албан бичгээр хүлээн авч, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг дээрх санал, танилцуулгад тусгана.

4.3 Үндэсний аудитын газрын Ёс зүйн зөвлөл энэ зааврын 2.3.2.1, 2.3.2.2-т заасан ерөнхий үнэлгээг бууруулах саналыг Санхүүгийн аудитын газар, Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газраас холбогдох нотлох баримт, тайлбар, танилцуулгын хамт албан бичгээр хүлээн авч, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, холбогдох шийдвэрийг Стратегийн удирдлагын газарт хүргүүлнэ.

⁴ Энэ зааврын 3.2-т заасан үнэлгээ

4.4 Ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээнээс хамаарч цаашид гаргах шийдвэр нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

№	Ерөнхий үнэлгээ		Үнэлгээний тайлбар	Гаргах шийдвэрийн утга
	Авсан оноо	Ангилал		
1	85-100	A	Гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн	Хэрэгжиж байгаа гэрээг сунгах боломжтой
2	55-84	B	Гэрээний үүргээ зарим талаар биелүүлээгүй	Дараагийн тендерт оролцох эрхтэй
3	0-54	C	Гэрээний үүргээ биелүүлээгүй	Хамтран ажиллах боломжгүй гэж үзэн “хар жагсаалт”-д оруулах


4.5 Стратегийн удирдлагын газар төрийн аудитын байгууллагын захиалгаар санхүүгийн тайлангийн аудит хийсэн хараар бус аудитын хуулийн этгээдийн гэрээний үүргийн биелэлт буюу ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн цаашид хэрхэн хамтарч ажиллах чиглэлийг аудит хийсэн байгууллага тус бүрээр гаргаж, Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.6 Хараат бус аудитын хуулийн этгээд энэ зааврын 3.4.1-д заасан үүргээ биелүүлэлгүй холбогдох мэдээ, судалгааг Төрийн аудитын байгууллагад тогтоосон хугацаанд нь албан ёсоор ирүүлээгүй тохиолдолд тухайн байгууллагыг үнэлгээг “0” гэж үнэлэн, гэрээний үүргээ биелүүлээгүйд тооцно.

4.7 Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн энэ зааварын 4.5-д заасан эцсийн үнэлгээ нь гэрээний үүргийн биелэлт болох тул аудитын үйлчилгээний төлбөрийг гүйцэтгэгчид шилжүүлэх үндэслэл болно. Ажлын гүйцэтгэлийн эцсийн үнэлгээ 0-54 буюу “C” авсан гүйцэтгэгчид аудитын үйлчилгээний төлбөр өгөхгүй. Энэ талаар гэрээнд тусгасан байна.

4.8 Ажлын гүйцэтгэлийг үнэлэхтэй холбоотой аливаа маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрнэ.

* * *



Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээний нэгтгэл

Төрийн аудитын байгууллага, нэгжийн нэр:

Огноо:

Тайлант хугацаа: 2022.11.04

№	Аудитын компанийн нэр	Ерөнхий үнэлгээ тооцох үндсэн үзүүлэлт				Ерөнхий үнэлгээ (EY)						Эзэлсэн байр	Тайлбар
						Тохируулга		Эцсийн үнэлгээ	Үүнээс				
		ЧХЕҮ	ХО	ТЗБҮ	Дундаж Хувь	Бууруулах хувь	Өсгөх хувь		85-100 А	55-84 В	0-54 С		
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	Нийт дундаж хувь												

- | | | | |
|---|--------|---|---|
| A | 85-100 | Гэрээний үүргээ бүрэн биелүүлсэн | Хэрэгжиж байгаа гэрээг сунгана |
| B | 55-84 | Гэрээний үүргээ зарим талаар биелүүлээгүй | Дараагийн тендерт оролцох эрхтэй |
| C | 0-54 | Гэрээний үүргээ биелүүлээгүй | Хамтран ажиллах боломжгүй гэж үзэн хар жагсаалтад оруулах |

Үнэлгээг нэгтгэсэн:

Хянаж зөвшөөрсөн:

Аудитын менежер

Овог нэр:

Газрын дарга/захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Овог нэр:

Ажлын баримт материал бүрдүүлэлтийн хувийг тооцох маягт

№	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын		Үе шатны ажлыг баримтжуулах ажлын баримтын		Ажлын баримт бүрдүүлэлт					Тайлбар
	Код	Нэр	Код	Нэр	Хийсэн аудитын код				Дундаж хувь	
					5	6	7	...		
A	1	2	3	4	5	6	7	
1	A1	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагын талаарх мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, шинэчлэх	A101	Байгууллагын талаарх ерөнхий мэдээлэл	1	1	0	1	75.00	
	A5	Аудитын ажлын нөхцөлийг үйлчлүүлэгчид танилцуулах	A501	Аудитын ажлын нөхцөл болон хариуцлагатай холбоотой нотлох зүйлсийн нэгтгэл	1	1	0	1	75.00	
2	B1	Үйлчлүүлэгч ба түүний гадаад, дотоод орчныг ойлгож, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох	B101	Байгууллага, түүний орчны ойлголтод үндэслэн материаллаг буруу эрсдэлийг урьдчилсан байдлаар тодорхойлох маягт	1	1	0	1	75.00	
	B2	Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох	B201	Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшин	1	1	0	1	75.00	
	B3	Тогтоосон эрсдэлийг үнэлж, баримтжуулах	B301	Тогтоосон эрсдэлийн үнэлгээ	1	1	0	1	75.00	
	B4	Аудитын явцад хэрэгжүүлэх горим, сорилыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох	B401	Илрүүлсэн эрсдэл, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын жагсаалт	1	1	0	1	75.00	
			B402	Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилыг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга	1	1	0	1	75.00	
	B5	Аудитыг төлөвлөх үе шатны ажлыг дуусвар болгох	B501	Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө	1	1	0	1	75.00	
B502			Санхүүгийн тайлангийн аудитын хөтөлбөр	1	1	0	1	75.00		
B503			Төлөвлөх үе шатны ажлыг дуусвар болгох хяналтын хуудас	1	1	0	1	75.00		
3	B1	Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	B101	Ажиллах нөхцлийг хангахтай холбоотой нотлох зүйлсийн нэгтгэл	1	1	0	1	75.00	
	B2	Төлөвлөсөн болон гүйцэтгэлийн шатанд нэмэгдсэн горим, сорилуудыг хэрэгжүүлэх	B20101	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн, нөхцөл байдал	1	1	0	1	75.00	
			B20102	Аудитыг гүйцэтгэх явцад шинээр нэмэгдсэн эрсдэлтэй асуудлын жагсаалт	1	1	0	1	75.00	
	B3	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг үнэлэх, баримтжуулах	B30101	Горим сорилын үр дүн, нөхцөл байдлыг алдаа, зөрчилд тооцох эсэхийг тогтоосон байдал	1	1	0	1	75.00	
			B30102	Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлыг үнэлж, шийдвэрлэсэн байдал	1	1	0	1	75.00	
	B4	Аудитыг гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох	B401	Аудитыг гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшин	1	1	0	1	75.00	
B5	Аудитын явц, үр дүнг үйлчлүүлэгчээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах, баримтжуулах	B501	Залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл	1	1	0	1	75.00		
B6	Гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусвар болгох	B601	Гүйцэтгэх үе шатны ажлыг дуусвар болгох хяналтын хуудас	1	1	0	1	75.00		
4	G1	Санхүүгийн тайлангийн аудитын үр дүнг нэгтгэх, баримтжуулах	G101	Аудитын гол үр дүнгийн нэгтгэл	1	1	0	1	75.00	
	G2	Аудитын санал дүгнэлтийн хэлбэрийг сонгож, баталгаажуулах	G201	Санал дүгнэлтийн хэлбэрийг сонгох шалгуур, үндэслэл	1	1	0	1	75.00	
	G3	Аудитын дүнг танилцуулах	G301	Аудитын үр дүнг танилцуулсан талаарх мэдээлэл	1	1	0	1	75.00	
	G4	Аудитын тайлан бэлтгэх	G401	Санхүүгийн тайлангийн аудитын дэлгэрэнгүй тайлан	1	1	0	1	75.00	
			G402	Хураангуй тайлан	1	1	0	1	75.00	
G5	Тайлагнах үе шатны ажлыг дуусвар болгох	G501	Тайлагнах үе шатны ажлыг дуусвар болгох хяналтын хуудас	1	0	0	1	50.00		
Д	D1	Аудитын мөрөөр хийх ажлыг хэрэгжүүлэх	D101	Аудитын мөрөөр хийсэн ажлын гүйцэтгэлийг нэгтгэж, үнэлсэн байдал	1	0	0	1	50.00	
	D2	Алдаа, зөрчлийг нэгтгэх, эрсдэлийн үнэлгээ хийх	D201	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн талаарх дүн шинжилгээ	1	1	0	1	75.00	

5	Д3	Статистик, мэдээ тайлан бэлтгэх	Д301	Санхүүгийн тайлангийн аудитын талаарх ерөнхий мэдээлэл	1	1	0	1	75.00
			Д302	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, түүнийг шийдвэрлэсэн байдал	1	1	0	1	75.00
			Д303	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, түүний хэрэгжилт, үр дүн	1	0	0	0	25.00
			Д304	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, түүний ангилал	1	1	0	1	75.00
Д4	Тайланг хугацааны бодлого, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах	Д401	Тайланг хугацааны бодлого, зорилтын хэрэгжилт, үр дүн	1	1	0	1	75.00	
Д5	Санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг нэгтгэж, баталгаажуулах	Д501	Санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ	1	0	0	1	50.00	
		Д502	Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийн ерөнхий үнэлгээ	1	1	0	1	75.00	
Д6	Аудитын тайланг сурталчлах, түгээх, архивлах	Д501	Аудитын тайланг сурталчлах, түгээх, архивлах ажлын үр дүн	1	1	0	1	75.00	
Үнэлгээний нийт дундаж хувь									71.32

Үнэлгээг нэгэсэн:

Аудитын менежер
овог нэр, гарын үсэг

Хүснэгт нөхөх заавар:

Энэ маягтыг компани тус бүрд бөглөнө

Бүх шатны чанарын хяналтын албан хаагчид ажлын баримт бүрдүүлэлтийг хангалттай, иж бүрэн гэж үзэж баталгаажуулсан бол "1" гэсэн сонголтыг хийнэ. Харин ажлын баримт материал бүрдүүлээгүй, чанарын хяналт хийгээгүй бол "0" гэсэн сонголтыг хийнэ.

Хийсэн аудит тус бүрийн тоогоор кодыг "хийсэн аудитын код" хэсэгт оруулж, хавсралт № 3-д өгсөн харгалзах оноог хуулж тавьна

Үе шатны ажил тус бүрийн дундаж оноог нийт хийсэн аудитын онооны жигнэсэн дундажаар тооцно

Үнэлгээний нийт дундаж хувийг үе шатны ажил тус бүрийн дундаж онооны жигнэсэн дундажаар тооцно

Жич: Энэ хүснэгтээр үнэлгээ хийж, баталгаажуулахдаа Хүснэгт нөхөх заавар хэсгийг устгана уу.

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:

..... Хараат бус аудитын компанийн захирал
овог нэр, гарын үсэг

Үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримталсан байдал

Компанийн нэр:

Аудитын код:

Аудитын нэр:

№	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны нэр	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын		Гүйцэтгэлийн хугацаа				Тайлбар
		Код	Нэр	Гүйцэтгэх хугацаа	Гүйцэтгэсэн хугацаа	Хугацаа хэтрүүлсэн хоног	Үнэлгээ хувиар	
A	1	2	3	4	5	6	7	8
1	Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат	A1	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагын талаарх мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, шинэчлэх				100.00	
		A5	Аудитын ажлын нөхцөлийг үйлчлүүлэгчид танилцуулах				100.00	
2	Аудитыг төлөвлөх үе шат	B1	Үйлчлүүлэгч ба түүний гадаад, дотоод орчныг ойлгож, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох				100.00	
		B2	Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох				100.00	
		B3	Тогтоосон эрсдэлийг үнэлж, баримтжуулах				100.00	
		B4	Аудитын явцад хэрэгжүүлэх горим, сорилыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох				100.00	
		B5	Аудитыг төлөвлөх үе шатны ажлыг дуусвар болгох				100.00	
3	Аудитыг гүйцэтгэх үе шат	B1	Төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх				100.00	
		B2	Төлөвлөсөн болон гүйцэтгэлийн шатанд нэмэгдсэн горим, сорилуудыг хэрэгжүүлэх				100.00	
		B3	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг үнэлэх, баримтжуулах				100.00	
		B4	Аудитыг гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох				100.00	
		B5	Аудитын явц, үр дүнг үйлчлүүлэгчээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах, баримтжуулах				100.00	
		B6	Гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусвар болгох				100.00	
4	Аудитыг тайлагнах үе	G1	Санхүүгийн тайлангийн аудитын үр дүнг нэгтгэх, баримтжуулах				100.00	
		G2	Аудитын санал дүгнэлтийн хэлбэрийг сонгож, баталгаажуулах				100.00	

5	Аудитын тайлагналын дараах үе шат	Г3	Аудитын дүнг танилцуулах			100.00
		Г4	Аудитын тайлан бэлтгэх			100.00
		Г5	Тайлагнах үе шатны ажлыг дуусвар болгох			100.00
		Д1	Аудитын мөрөөр хийх ажлыг хэрэгжүүлэх			100.00
		Д2	Алдаа, зөрчлийг нэгтгэх, эрсдэлийн үнэлгээ хийх			100.00
		Д3	Статистик, мэдээ тайлан бэлтгэх			100.00
		Д4	Тайлант хугацааны бодлого, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах			100.00
		Д5	Аудитын тайланг сурталчлах, түгээх, архивлах			100.00
		Үнэлгээний нийт дундаж хувь				100.00

Үнэлгээ өгсөн:

Аудитын менежер

овог нэр, гарын үсэг

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:

..... Хараат бус аудитын компанийн захирал

овог нэр, гарын үсэг

Хүснэгт нөхөх заавар:

Энэ хүснэгт аудит тус бүрээр хөтлөгдөнө.

Хүснэгтийн 4-5 дугаар баганын хугацааг аудитын хөтөлбөрт заасан хугацаатай ижил байхаар тооцно.

Хүснэгтийн 6 дугаар баганын хугацаа хэтрүүлсэн хоногийг тооцож гаргахдаа ажлын өдрөөр тооцож гаргана.

Хүснэгтийн 7 дугаар баганын үнэлгээг тооцохдоо үе шатны ажлыг хугацаандаа биелүүлсэн бол 100 хувь гэж тооцох бөгөөд хугацаа хоцроосон хоног тутмыг 2 дахин нэмэгдүүлж, үе шатны ажлын гүйцэтгэлийн хувиас хасна.

Хүснэгтийн 34 дүгээр мөрөнд байгаа үнэлгээний нийт дундаж хувийг нийт 26 үе шатны ажлын дундаж хувиар тооцно.


Жич: Энэ хүснэгтээр үнэлгээ хийж, баталгаажуулахдаа Хүснэгт нөхөх заавар хэсгийг устгана уу.

Үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг үнэлсэн байдал

Компанийн нэр:

Аудитын код:

№	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны нэр	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын		Хийсэн аудитын код/Ажил гүйцэтгэсэн хугацаанд өгсөн үнэлгээний хувь			Үнэлгээний дунаж хувь	Тайлбар
		Код	Нэр					
A	1	2	3	4	5
1	Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат	A1	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагын талаарх мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, шинэчлэх				-	
		A5	Аудитын ажлын нөхцөлийг үйлчлүүлэгчид танилцуулах				-	
2	Аудитыг төлөвлөх үе шат	B1	Үйлчлүүлэгч ба түүний гадаад, дотоод орчныг ойлгож, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох				-	
		B2	Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох				-	
		B3	Тогтоосон эрсдэлийг үнэлж, баримтжуулах				-	
		B4	Аудитын явцад хэрэгжүүлэх горим, сорилыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох				-	
		B5	Аудитыг төлөвлөх үе шатны ажлыг дуусвар болгох				-	
3	Аудитыг гүйцэтгэх үе шат	B1	Төлөвлөсөн болон гүйцэтгэлийн хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх				-	
		B2	Төлөвлөсөн болон гүйцэтгэлийн шатанд нэмэгдсэн горим, сорилуудыг хэрэгжүүлэх				-	
		B3	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг үнэлэх, баримтжуулах				-	
		B4	Аудитыг гүйцэтгэх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох				-	
		B5	Аудитын явц, үр дүнг үйлчлүүлэгчээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах, баримтжуулах				-	
		B6	Гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусвар болгох				-	
4	Аудитыг тайлагнах үе шат	Г1	Санхүүгийн тайлангийн аудитын үр дүнг нэгтгэх, баримтжуулах				-	
		Г2	Аудитын санал дүгнэлтийн хэлбэрийг сонгож, баталгаажуулах				-	
		Г3	Аудитын дүнг танилцуулах				-	
		Г4	Аудитын тайлан бэлтгэх				-	



		Г5	Тайлагнах үе шатны ажлыг дуусвар болгох					
5	Аудитын тайлагналын дараах үе шат	Д1	Аудитын мөрөөр хийх ажлыг хэрэгжүүлэх					
		Д2	Алдаа, зөрчлийг нэгтгэх, эрсдэлийн үнэлгээ хийх				YXA0122	
		Д3	Статистик, мэдээ тайлан бэлтгэх				-	
		Д4	Тайлант хугацааны бодлого, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах				-	
		Д5	Аудитын тайланг сурталчлах, түгээх, архивлах				-	
			Үнэлгээний нийт дундаж хувь				-	

Үнэлгээг нэгэсэн:

Аудитын менежер
овог нэр, гарын үсэг

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:

..... Хараат бус аудитын компанийн захирал
овог нэр, гарын үсэг

Хүснэгт нөхөх заавар:

Энэ хүснэгт аудитын компани тус бүрээр хөтлөгдөнө.

Хүснэгтийн 4-өөс хойших багананд үе шатны ажлыг гүйцэтгэх хугацааг баримтлоогийн хүснэгтийн мэдээллийг оруулна.

Үе шатны ажлын хугацааг баримталсан байдалд үнэлгээ өгөхдөө нийт хийсэн аудитын жигнасан дундажаар тооцно.

Хүснэгтийн 34 дүгээр мөрөнд байгаа үнэлгээний нийт дундаж хувийг нийт 26 үе шатны ажлын дундаж хувиар тооцно.

Жич: Энэ хүснэгтээр үнэлгээ хийж, баталгаажуулахдаа Хүснэгт нөхөх заавар хэсгийг устгана уу.

Үе шатны ажлын чанарын хяналтын үнэлгээ

№	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны нэр	Санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын		Чанарын хяналтын үнэлгээ тооцох үзүүлэлт (1-5)						Дундаж хувь	Тайлбар
		Код	Нэр	Үе шатны ажлыг хэрэгжүүлэх алхамыг иж бүрэн гүйцэтгэсэн эсэх	Цуглуулсан нотлох зүйлийн чанар байдал						
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Аудитыг төлөвлөхийн өмнөх үе шат	A1	Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах байгууллагын талаарх мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, шинэчлэх						0	0	
		A5	Аудитын ажлын нөхцөлийг үйлчлүүлэгчид танилцуулах						0	0	
2	Аудитыг төлөвлөх үе шат	B1	Үйлчлүүлэгч ба түүний гадаад, дотоод орчныг ойлгож, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох						0	0	
		B2	Аудитыг төлөвлөх үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох						0	0	
		B3	Тогтоосон эрсдэлийг үнэлж, баримтжуулах						0	0	
		B4	Аудитын явцад хэрэгжүүлэх горим, сорилыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйг тодорхойлох						0	0	
		B5	Аудитыг төлөвлөх үе шатны ажлыг дуусвар болгох						0	0	
3	Аудитын гүйцэтгэл үе шат	B1	Төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх						0	0	
		B2	Төлөвлөсөн болон гүйцэтгэлийн шатанд нэмэгдсэн горим, сорилуудыг хэрэгжүүлэх						0	0	
		B3	Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг үнэлж, баримтжуулах						0	0	
		B4	Аудитын гүйцэтгэл үеийн материаллаг байдлын түвшнийг тодорхойлох						0	0	
		B5	Аудитын явц, үр дүнг үйлчлүүлэгчээр хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулах, баримтжуулах						0	0	
		B6	Гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусвар болгох						0	0	
4	Аудитыг тайлагнах үе шат	G1	Санхүүгийн тайлангийн аудитын үр дүнг нэгтгэх, баримтжуулах						0	0	
		G2	Аудитын санал дүгнэлтийн хэлбэрийг сонгож, баталгаажуулах						0	0	
		G3	Аудитын дүнг танилцуулах						0	0	
		G4	Аудитын тайлан бэлтгэх						0	0	
		G5	Тайлагнах үе шатны ажлыг дуусвар болгох						0	0	
5	Аудитын тайлагналын дараах үе шат	D1	Аудитын мөрөөр хийх ажлыг хэрэгжүүлэх						0	0	
		D2	Алдаа, зөрчлийг нэгтгэх, эрсдэлийн үнэлгээ хийх						0	0	
		D3	Статистик, мэдээ тайлан бэлтгэх						0	0	
		D4	Тайлант хугацааны бодлого, зорилтын хэрэгжилтийг үнэлэх, тайлагнах						0	0	
		D5	Аудитын тайланг сурталчлах, түгээх, архивлах						0	0	
		Дундаж хувь									

Үнэлгээ өгсөн:

Аудитын менежер

овог нэр, гарын үсэг

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:

..... Хараат бус аудитын компанийн захирал

овог нэр, гарын үсэг

Хувь оролцоо (ХО) буюу хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн ажлын нийт үр дүнд оруулсан хувь нэмэрийг тооцох үзүүлэлт

№	Компанийн нэр	Тайлан хугацаанд хийсэн залруулга		Хүлээн зөвшөөрүүлж, бүртгэсэн үр өгөөж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Сахилгын шийтгэл ногдуулах санал		Тайлбар
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
		15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27

Үнэлгээг нэгэсэн:

Аудитын менежер

овог нэр, гарын үсэг

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:

..... Хараат бус аудитын компанийн захирал

овог нэр, гарын үсэг

Төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээ (ТЗБҮ) буюу хараат бус аудитын жилийн этгээдийн илрүүлсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын үнэлгээ тооцох үзүүлэлт

№	Компанийн нэр	Зөвлөмж						Төлбөрийн акт						Албан шаардлага						Тайлбар						
		Өмнөх тайлант хугацаанд илрүүлээд барагдуулаагүй байсан үлдэгдэл (Өссөн дүнгээр)			Тухайн тайлант хугацаанд илрүүлсэн			Өмнөх тайлант хугацаанд илрүүлээд барагдуулаагүй байсан үлдэгдэл (Өссөн дүнгээр)			Тухайн тайлант хугацаанд илрүүлсэн			Өмнөх тайлант хугацаанд илрүүлээд барагдуулаагүй байсан үлдэгдэл (Өссөн дүнгээр)			Тухайн тайлант хугацаанд илрүүлсэн									
		Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан	Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан	Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан	Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан	Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан	Тоо	Дүн	Үүнээс: Тухайн тайлант хугацаанд барагдуулсан		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
				Тоо			Дүн			Тоо			Дүн			Тоо			Дүн							
Үзүүлэлт																										
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26
		27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	41	42	43	44	45	46	47	48	49	50	51

Үнэлгээг нэгэсэн:
Аудитын менежер
овог нэр, гарын үсэг

Үнэлгээтэй танилцаж зөвшөөрсөн:
..... Хараат бус аудитын компанийн захирал
овог нэр, гарын үсэг